



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.25 № 682

танай _____-ны № _____-т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ ДАРХАН СУМЫН
МАН-ЫН ХОРООНЫ ДАРГА
Ж.ЭНХТӨР ТАНАА

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд Г
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хэнтий аймгийн Дархан сумын МАН-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн

232420710

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хэнтий аймгийн Дархан сумын МАН-ын хорооны аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хэнтий аймгийн Дархан сумын МАН-ын хорооны мөрийн хөтөлбөр (7 хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Хэнтий аймгийн Дархан сумын сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Ж.ГАНБААТАР/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР /Д.ОЮУНТУЯА/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР /Д.ЭРДЭНЭБИЛЭГ/

АУДИТОР /Ц.ХАТАНБОЛД/




/

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ
АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Орон сууц
- 1.2. Эрүүл мэнд
- 1.3. Боловсрол
- 1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт
- 1.5. Соёл, спорт
- 1.6. Хүүхэд гэр бүлийн хөгжил



ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Хөдөө аж ахуй
- 2.2. Аялал жуулчлал
- 2.3. Дэд бүтэц
- 2.4. Авто зам

ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО



НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд Дархан сумын төвд 12 айлын орон сууц барьж, иргэдэд ипотекийн зээлэнд хамрагдах боломжийг судлана.

1.2. Эрүүлмэнд

1.2.1. Орон нутагт дутагдалтай байгаа эмч, мэргэжилтнийг бэлтгэх бодлогыг тодорхойлж, хүний нөөцийн нийгмийн баталгааг ханган ажиллана.

1.2.2. намын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэгийг тасралтгүй үргэлжлүүлж, эрт илрүүлгийг нэмэгдүүлнэ.

1.2.3, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.4.“Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн” хөтөлбөрүүдийг орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.3. Боловсрол

1.3.1 Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг барьж ашиглалтанд оруулна.

1.3.2 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургуулийн 100 хүүхдийн дотуур байр барьж ашиглалтанд оруулна.

1.3.3. Хүүхэд бүрийг сургуулийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.

1.3.4. Бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлж, хүүхдийн өөрийнхнь авьяаст тулгуурлан хүүхдийг хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.




1.3.5. Нүүдлийн соёлын чадавхыг ерөнхий боловсролын сургалтаар өгөх, бэхжүүлэх хүрээнд биеийн тамирын хичээлийн агуулгад үндэсний бөх, технологийн хичээлд хатгамал, дээл оёх, хөгжмийн хичээлд уртын дуу, морин хуур, биелгээг оруулна.

1.3.6. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.3.7. Ерөнхий боловсролын сургуульд байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори байгуулна.

1.3.8. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, байдлыг хангана.

1.3.9. Сум орон нутагт шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор “Зөгийн үүр” арга хэмжээг хэрэгжүүлнэ.



1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт

1.4.1. Иргэдийг хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлээр мэргэжлийн сургалтад хамруулан бүтээмжтэй, зохистой ажлын байрыг бий болгох замаар, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилтай, орлоготой болгож, ядуурлын түвшинг бууруулна.

1.4.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулж, оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг дэмжиж хөгжүүлнэ.

1.4.3. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлсэн тохируулгатай ажлын байр бий болгосон жишиг байгууллага, аж ахуйн нэгжийг жил бүр шалгаруулан урамшуулна.

1.5.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.



1.5. Соёл, спорт

1.5.1. Суманд спорт заал барьж ашиглалтанд оруулна.


1.5.2. Орон нутаг сурталчлах танхимын барилга барина.

1.5.3. Соёлын төвийн бүжгийн заалыг засварлана.

1.5.4 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, хөдөлгөөнт дасгал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.5.5 Улсын болон аймаг сум, олон улсын чанартай тэмцээн уралдаанд хүүхэд залуучуудыг бэлтгэнэ.

1.4.6. Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын аймаг, бүс, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.



1.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжил

1.6.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх сумын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.6.2. Хүүхэд гэр бүлд үзүүлэх хөгжлийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн, нийт хүүхэд гэр бүлийн 50 хувьд үйлчилгээ үзүүлнэ.

1.6.3. Гэр бүл, хүүхдэд сургалт хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг сургалтын баазтай болно.

1.6.4. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.



ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуй

2.1.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлэх.

2.1.2. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, "Монголмал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.3. Усалгаатай газар тариаланг хөгжүүлэн, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн хэрэгцээг бүрэн хангана.

2.1.4 Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд өвсний фондод өвс нөөцөлнө.

2.1.5. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.1.6. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг сумын хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.

2.1.7. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

2.1.8. Мал амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хяналт, сэргийлэлт, яаралтай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төвийг байгуулна.

2.2. Аялал жуулчлал

2.2.1. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан газруудад хувийн хэвшил, иргэдтэй хамтран аялал жуулчны бааз байгуулна.

2.2.2. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, чадавхижуулах, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.



2.3. Дэд бүтэц

2.3.2. Дархан тохижилт төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллгаагаар сайжруулж, сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжийг инженерийн шугам сүлжээнд холбоно.

2.3.3. Сумын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.

2.3.4. Сумын доторх 2,9 км хатуу хучилттай авто замыг барьна.

2.3.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдийг орон сууцжуулах ажлыг эхлүүлж урьдчилгаа төлбөрийн батлан даалт, ипотекийн зээлийн асуудлыг шийдвэрлэнэ.

2.3.6. Багуудад үүрэн телефоныг сүлжээг өргөтгөнө.

2.3.7. Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээл олгох ажлыг боломжийг судлан хэрэгжүүлнэ.

ГУРАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Хог хаягдлын цогц менежментийг хог хаягдлын зориулалтын байгууламжтай болно.

3.2. Хог хаягдал ангилан ялгах цехийг байгуулна.

3.3. Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ.

3.5. Хог шатаах зуухыг авч ашиглалтанд оруулна.

3.4. Жил бүр 15 мянган мод тарих замаар ойн сан, хамгаалалтын ойн зурвасыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулж “Тэрбуммод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангана.



ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1 Тендэр сонгон шалгаруулалт, газар олголт, орон нутгийн эд хөрөнгийн дуудлага худалдааг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх боломжийг бий болгоно.

4.2 Төрийн нууцад хамаарахаас бусад гэрээ, хэлцэл мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй ил тод болгоно.

4.3 Зэгийн үүр хөтөлбөрийг хэрэгжүүлж орон нутагт шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарч ажиллана.

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1 Дархан сумын гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.

5.2 Дархан суманд ундны усны худаг гаргаж, цэвэр усны хангалтыг нэмэгдүүлнэ.

5.3 Дархан сумын Шажин багт үүрэн холбооны сүлжээ барьж байгуулна.

5.4 Дархан сумын Мандах наран хороололын газар олголтын асуудлыг шийдвэрлэж айлуудын хашааг бүрэн барьж дуусгуулна.

